



ИНТЕЛЛЕКТ ТАУЭР ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Г.ОЮУНТУНГАЛАГ ТАНАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

Нийслэлийн Засаг захиргааны III байр,
Ж.Самбууний гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170

Утас: (976) 7799 0101

Цахим шуудан: ubhd@emg.ub.gov.mn

Цахим хуудас: www.ubhealth.mn

1024.05.14 № 10-13-02/036/300.

Зураг төсөлд эрүүл ахуйн
хяналт хийсэн тухай

Тус газарт ирүүлсэн албан хүсэлтийн дагуу Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5.1.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 10-00/02 дугаартай “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгаар баригдах дээрээ тохижилт бүхий газар доорх автозогсоол, үйлчилгээний цогцолборын барилгын ажлын зураг төсөл, холбогдох бичиг баримтад 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр эрүүл ахуйн хяналт хийлээ.

Нэг. Барилга байгууламжийн нэр:

Нийслэлийн ерөнхий архитекторын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу олгосон МЗХ2024/00-103 дугаартай архитектор төлөвлөлтийн даалгавар, Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар, ерөнхий архитекторын ажлын албаны 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн загвар зурагтай.

Хоёр.Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр:

Ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, барилга бүтээц, барилгын дотор халаалт, агаар сэлгэлт, цэвэр бохир ус, ажлын зураг төслийг 2024 онд Интеллект тауэр ХХК-д, холбоо дохиоллын ажлын зураг төслийг 2024 онд Анод Катод ХХК-д тус тус боловсруулсан./шифр: AC-16/2024/. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дээрээ тохижилт бүхий газар доорхи авто зогсоол, үйлчилгээний цогцолборын барилгын ажлын зураг төсөл.

Гурав.Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл

Нийслэлийн Засаг даргын 2024 оны A/275 дугаартай захирамжтай, 1500100170 нэгж талбарын дугаартай, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр, 40, 50 мянгат-2 (15171) бүсчлэлд Улаанбаатар хотын төлөвлөлтийн төвийн бусийн 6 дугаар нэгж хороолол,

1550001224

Жуулчны гудамж дагуу байршуулан Үйлчилгээ, ногоон байгууламж, тохижилт бүхий газар доорх нийтийн хэрэгцээний автозогсоол зориулалтаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт эзэмшүүлэн олгосон, 0000247943 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээтэй, 1.38 га газрыг үндэслэсэн байна.

Дөрөв.Зураг төслийн товч агуулга:

Төлөвлөж буй барилга нь 1, 2, 3, 4 хэсэгтэй Нэгдсэн автозогсоол ба үйлчилгээний төв барихаар төлөвлөсөн байна. Үүнд:

Төлөвлөж буй нэгдсэн авто зогсоол нь 1, 2, 3, 4 хэсгээс бүрдэх бөгөөд нийт 4786.17м.кв талбай бүхий 4 хэсэгтэй ба хооронд нь холбоос хонгилтой, холбоос хонгил 1 болон 3 дахь хэсэгт ногоон байгууламжуу гарсан шат, 1 дүгээр нэгдсэн авто зогсоолд 1, 2 дугаар нэгдсэн авто зогсоолд 2, 3 дугаар нэгдсэн авто зогсоолд 2, 4 дүгээр нэгдсэн авто зогсоолд 1 ширхэг гэгээвч (фонарь) тус тус төлөвлөсөн. Дээрхи нэгдсэн авто зогсоол нь нийт 107 зогсоолтой ба үүнээс 4 нь цахилгаан автомашинд, 8 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байхаар;

Төлөвлөж буй үйлчилгээний төв нь тэнхлэгээрээ 30.0м x 31.0м хэмжээтэй, төмөр бетон карказан бүтээц бүхий хийцлэлтэй, хавтгай дээвэртэй, зоорьтой, 3 давхар, 2 орцтой байхаар төлөвлөсөн байна. Тус барилгын зоорийн давхарт 10м.кв- 335м.кв шат, шатны хонгил, узелийн өрөө, холбоо дохиоллын өрөө, цахилгааны өрөө, агуулах, галын усны өрөө байхаар;

1 дүгээр давхарт: 138.34м.кв өвлийн цэцэрлэг, 137.24м.кв кофе шол, 36.01м.кв генераторын өрөө, 20.29м.кв гал тогоо, 21.73м.кв- 36.05м.кв үйлчилгээний өрөө, нийтийн эзэмшлийн талбайд гонх, эрэгтэй, эмэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөнүүд, шат, лифтний хонгилууд байхаар;

2 дугаар давхарт: 322.25м.кв үзэсгэлэнгийн (галлерей) өрөө, 33.65м.кв- 68.31м.кв оффисын өрөө, 10.87м.кв- 36.44м.кв үйлчилгээний өрөө, нийтийн эзэмшлийн талбайд эрэгтэй, эмэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөнүүд, шат, лифтний хонгилууд байхаар;

3 дугаар давхарт: 21.73м.кв- 417.37м.кв үйлчилгээний өрөө, талбай, 41.28м.кв оффисын өрөө, нийтийн эзэмшлийн талбайд эрэгтэй, эмэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөнүүд, шат, лифтний хонгилууд байхаар тус тус төлөвлөсөн.

Барилгын техникийн давхар нийт 303.24 м.кв талбайтай, лифтний хонгил 5.12м.кв- 6.14м.кв, узелийн өрөө 158.89м.кв, шатны хонгил 33.13м.кв, коридор 56.54м.кв байхаар төлөвлөсөн байна.

Ус хангамж: Ус сувгийн удирдах газрын техникийн нөхцөл олгох комиссын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 166/24 дугаартай техникийн нөхцөл авсан.

Цахилгаан хангамж: Улаанбаатар Цахилгаан Түгээх сүлжээ Төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 01/01459/24 дугаартай техникийн нөхцөлтэй.

Агааржуулалт: Барилгын зоорийн давхарт ердийн болон механик агаар сэлгэлтийн систем төлөвлөсөн ба агаар оруулах, сорох механик систем, нийтийн ариун цэврийн өрөө болон гал тогооны өрөөнд ердийн сорох систем тус тус төлөвлөсөн байна.

Инженер геологийн судалгааг Барилгын Инженер-хайгуулын Инженер геологи номт ХХК-ийн 2024 онд хийсэн дүгнэлтэд судалгааны талбайд сувалтар овойлттой инженер-геологийн 2 төрлийн элемент илэрсэн, инженер-геологийн төвөгтэй нөхцөлд хамарагдах ба газар чичирхийллийн 8 баллын бүсэд байрладаг, талбайд өрөмдсөн цооногт ан цавын гаралтай ус 2.70- 5.50 метрээс илэрсэн, барилга байгууламжийн суурь нээх үед суурийн хяналт, хөрсний хяналт хийлгэх шаардлагатай гэж дүгнэсэн байна. Архивын №24/080, 3Т11-132/24.

Ажлын зураг төслийг хянаад дараах зүйлсийг анхаарч, хэрэгжүүлэх:

1.Хөрсний уснаас хамгаалах арга хэмжээг зураг төсөлд норм, дүрмийг баримтлан тодорхой тусгаж өгөх, барилга байгууламжийн суурь нээх үед суурийн хяналт хийлгэх шаардлагатай;

2.Үүсмэл хөрсийг бүрэн хуулж авах;

3.Барилга байгууламжаас ялгараах хог хаягдлын хэмжээнд тохирсон багтаамж бүхий ангилан ялгалттай хогийн цэг, түүнийг хэрхэн цуглуулж, зайлзуулах талаар барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөөнд тусгах;

4.Үйлчилгээний барилгын доторхи өрөө тусгаарлах зарим хаалганы онгойх чиглэлийг гадагш чиглэлтэй болгох;

5.Нэгдсэн гаражийн 4 хэсэг тус бүрт угаарын хий (СО)-н бөөгнөрлийг хэмжих хэрэгсэл суурилуулах;

Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг үндэслэн **ДҮГНЭХ НЬ:** Барилгын зураг төслийг Интеллект тауэр ХХК-д боловсруулсан, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дээрээ тохижилт бүхий газар доорх автозогсоол, үйлчилгээний цогцолборын барилгын зураг төсөл нь дээрхи шаардлагыг хангасан нөхцөлд Монгол Улсын Барилгын норм ба дүрэм. Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03, Автозогсоол БНБД 21-05-10 -д шаардлагад нийцнэ.

Та улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзвэл Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх, заалтын дагуу гомдол гаргах эрхтэй.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Г.ЭНХМАА



ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ЗАХИРАЛ - 2

Архивист

Банжурэл

Г.ОЮУНТУНГАЛАГ